



**“МОНГОЛ АЛТ”ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 06 өдөр

№ 02

Дархан уул аймаг

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжид хурлыг  
зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71.3, “Монгол-Алт” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2, 9 дүгээр зүйлийн 9.6.13, 9.12, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 12-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 4 дүгээр бүлгийг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол-Алт” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2023 оны 04 сарын 21-ний өдрийн 10:00 цагт зарлан хуралдуулсугай.
2. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 03 сарын 14-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн биржид хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллээр дамжуулан 2023 оны 03 сарын 09-ний дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2023 оны 03 сарын 24-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахих нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03 сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 03 сарын 17-ны өдөрт багтаан брокер, дилперийн компаниудад хүргүүлэхийг гүйцэтгэх захирал М.Цолмонд үүрэг болгосугай.
6. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Л.Амарсанааг томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

М.Цолмон	Гүйцэтгэх захирал
Ж.Мягмаа	Ерөнхий нягтлан бодогч
Х.Одгэрэл	Хүний нөөцийн ажилтан
Х.Намуундарь	Нягтлан бодогч
Б.Батцэцэг	Нягтлан бодогч

8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1-р хавсралтаар, саналын хуудасны загварыг 2-р хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарыг 3-р хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 4-р хавсралтаар баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн санал хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 04 сарын 21 –ний өдрийн /хурал эхлэх цагтай ижил байх/ 10.00 цаг байхаар тогтоосугай.
- 10.Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Ж.Мягмаа/-д даалгасугай.
- 11.Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Х.Одгэрэл                   Хүний нөөцийн ажилтан

Х.Намуундарь               Нягтлан бодогч

Б.Батцэцэг               Нягтлан бодогч

12. Компанийн дүрмийн 8.12.4-т заасны дагуу санал хураалтыг явуулахыг Гүйцэтгэх захирал М.Цолмонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

М.ЦОЛМОН

